



**МОНГОЛ УЛСЫН  
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан даалгавар, 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаал, Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сахилга, хариуцлага дэг журмыг чангатгах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгавруудыг хэрэгжүүлэх зорилгоор Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих үүрэг бүхий "Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл" /ХШДАЗ/-ийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчилсүгэй. Үүнд:

Зөвлөлийн дарга: Хууль тогтоомж, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн


Гишүүд: Олон улсын гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн  
Олон улсын гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

2. Дээр дурдсан Зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Байгууллагын Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөлийн ажиллах журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг ХШДАЗ /Зөвлөлийн дарга, Хууль тогтоомж, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Далайн захиргааны даргын 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТҮВШИНТӨР

0000000016

Далайн захиргааны даргын 2020 оны 01 дугаар сарын 31 ний өдрийн 08 тоот тушаалын хавсралт



Далайн захиргааны Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөлийн ажиллах шинэчилсэн журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Далайн захиргаанаас авч хэрэгжүүлж байгаа далайн болон усан замын тээврийн салбарын хөгжлийн баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайлагналт, үр дүнд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих үүрэг бүхий "Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл" /цаашид ХШДАЗ гэх/ нь үйл ажиллагаандаа Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь байгууллагын үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, сахилга хариуцлагыг сайжруулахад оршино.

1.4. Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл нь жил бүр хяналтын ажлын төлөвлөгөө гарган ажиллах бөгөөд гишүүдийн хариуцан гүйцэтгэх үүргийг тэдний ажлын байрны тодорхойлолтод тусгуулах арга хэмжээ авна.

### Хоёр. Хяналт шинжилгээ, дотоод аудитын ажлын зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь байгууллагын удирдлагаас Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон жилийн ажлын төлөвлөгөөний талаарх ажилтан болон холбогдох бүх нэгж /алба, хэлтэс/-үүдийн саналыг тусгасан төслийг эцэслэн хянаж удирдлагад танилцуулна.

2.2. Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах ажлыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хариуцах бөгөөд Зөвлөл нь түүний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, дотоод аудит хийж ажиллана.

2.3. Бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн нь тогтмол гаргаж өгөх тайлан, мэдээг албаны ахлах мэргэжилтнүүдээс авч нэгтгэн гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэхээс 3-5 хоногийн өмнө хяналт шинжилгээ, дотоод аудит хийлгэхээр Зөвлөлд өгнө.

2.4. ХШДАЗ нь байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн байдалд гэнэтийн хяналт, шалгалт явуулах, удирдах дээд байгууллагын тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөний улирал, хагас, бүтэн жилийн биелэлт, ажлын тайланд хяналт шинжилгээ, аудит хийж саналаа удирдлагад танилцуулах бөгөөд уг тайлан мэдээг заасан хугацаанд багтаан холбогдох газруудад хүргүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

Гурав. Хяналт шинжилгээ, дотоод аудит хийх хүрээ

3.1. Байгууллагын хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл нь дараах ажлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна:

3.1.1. Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад мөрдлөг болохуйц тодорхой дүгнэлт, санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайлангийн дүгнэлт, санал, зөвлөмжид үндэслэн холбогдох алба, албан тушаалтнаас тухайн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч байгаа байдалд хяналт тавих;

3.1.3. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөлийн ажлын тайланг холбогдох журмын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж, дараа оны 1 дүгээр улиралд багтаан Бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх;

3.1.4. Ажилтнуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж дүгнэхдээ Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг баримтлах;

3.1.5. Иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотойгоор ирүүлсэн мэдээллийг шалган тогтоох, байгууллагын удирдлагад мэдэгдэх, хариуцлага тооцох санал гаргах;

3.1.6. Өргөдөл, гомдол, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн явц, байдалд хяналт тавих;

3.1.7. Ажилтны ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахиж байгаа байдалд хяналт тавьж зөрчил гаргасан тохиолдолд хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулах талаар санал гаргаж шийдвэрлүүлэх;

3.1.8. Ажилтан ажлын цагийг чанд баримталж, ажил таслах, хоцрох, эрт тарах зэрэг асуудлыг таслан зогсоох зорилгоор ажлын цагийн бүртгэлийн байдалд хяналт тавих;

3.1.9. Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн дагуу ажилтан ажлаа бүрэн, оновчтой төлөвлөж, биелэлтийг хангаж байгаа байдалд болон ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь ажлын байрны тодорхойлолттой уялдсан эсэхэд хяналт тавих;

3.1.10. Ажилтан захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлан өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж байгаад болон удирдлагын шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих;

3.1.11. Байгууллагын хэмжээнд дотоод хяналт, шалгалтын ажлыг системтэй зохион байгуулж, Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн үйлдэл, илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгаж, буруутай удирдах албан тушаалтан, ажилтанд тухай бүр хариуцлага тооцож байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.12. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр хийсэн гэнэтийн хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах, удаа дараа зөрчил гаргасан ажилтанд хариуцлага тооцох санал боловсруулж удирдлагад танилцуулах;

3.1.13. Ажилтны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг бодитой, үнэн зөв дүгнэж байгаад хяналт тавьж үр дүнгийн үнэлгээнд тулгуурлан урамшуулал олгох, эсэх асуудлаар санал гаргах;

3.1.14. Ажилтны үйл ажиллагааны төлөвлөлт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын үр дүнд хяналт шинжилгээ хийж санал, зөвлөмж гарган холбогдох арга хэмжээ авч байх;

3.1.15. Хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.16. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсанд холбогдох мэдээллийг тогтмол оруулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөдөлмөр хамгаалалын хувцас, хэрэгслийн хангамж, хэрэглээ, хадгалалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байгаа байдалд дангаар болон хамтарсан шалгалт явуулж холбогдох арга хэмжээ авч ажиллах зэргээр байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, дотоод аудит хийх;

3.1.18. албан тушаалтан, ажилтны үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.1.19. төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад гэм хор учруулсан бол гэм хорыг арилгах, байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах талаар санал гаргах.

#### Дөрөв. Хяналт шинжилгээ, дотоо аудит хийх зарчим

4.1. Хяналт шинжилгээ, дотоод аудит хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.1.1. шударга, хараат бус байх;

4.1.2. хяналт шинжилгээ, дотоод аудитын үйл ажиллагаа нээлттэй, зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмж нь ил тод байх;

4.1.3. хяналт шинжилгээ, аудитын санал, зөвлөмж нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

4.1.4. хяналт шинжилгээ, аудит хийж гаргасан санал, зөвлөмж нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон байх;

4.1.5. хяналт шинжилгээг тасралтгүй, дотоод аудитыг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

4.1.6. хяналт шинжилгээ, дотоод аудит хийхдээ удирдах ажилтан, албаны ахлах мэргэжилтний оролцоог хангасан байх;

4.1.7. тайлан, төлөвлөгөөний биелэлтэд тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг мэдээллийг гаргаж өгсөн тухайн албан тушаалтан хариуцдаг байх.

#### Тав. Хариуцлага

5.1. Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээний дүнгээр хагас, бүтэн жилээр дараалан хангалтгүй үнэлгээ авсан, хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан

ажилтанд тухай бүр хариуцлага тооцож холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах тухай саналаа байгууллагын удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх эрхтэй.

5.2. Дараах зөрчил гаргасан ажилтанд Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх талаар санал гаргаж Даргын зөвлөлд танилцуулна. Үүнд:

5.2.1. Энэхүү журмын 2.3.-т заасан тайлан, мэдээний хугацааг хожимдуулсан, худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

5.2.2. Зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийг удаа дараа биелүүлээгүй;

5.2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн үнэлгээгээр удаа дараа хангалтгүй үнэлгээ авсан.

- оОо -